# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

*/Байгаль орчны газар/*

2025.12.08 /2025 оны жилийн эцсийн байдлаар/

| Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ | Үр дүн, үр нөлөө | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1. МУ-ЫН ХУУЛЬ-4** | | | | | | | |
| 1 | 1 | Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 | 39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн захиргааны байгууллагуудтай хамтарсан болон байгаль хамгаалагчийн өдөр дутмын эргүүл, хяналт шалгалтыг 63 хоногийн хугацаанд зохион байгуулж 900 гаруй иргэн 33 ААНБ-д, 26 малчин өрх, 14 ойн нөхөрлөлд 832 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шинэчилсэн гарын авлага түгээж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн Газраас хэрэгжүүлж байгаа “Ойн түймэртэй тэмцэх, чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд 16 ойн нөхөрлөлд 7 төрлийн 55 ширхэг ой, хээрийн түймэр унтраах багаж, анхны тусламжын хэрэгслийг олгож, дэмжлэг үзүүлж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2025 оны төлөвлөгөөний | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.4 дэх заалт | Ойн түймэр бүртгэгдээгүй | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжилтийг ИТХ-д танилцуулж, аймгийн хэмжээнд 2026 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2025 оны 03/51 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажилллаа. | | | |
| 2 | 2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.6.10. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Байгууллагын boajg.or.gov.mn цахим мэдээллийн хуудсанд байгууллагын “Орхон аймгийн Байгаль орчны газар” олон нийтийн цахим мэдээллийн хуудсыг нэггтэж, тогтмол шинэчлэх нөхцлийг бүрдүүллээ. Мөн shilen.gov.mn, gov.mn, зэрэг цахим мэдээллийн санд байгууллагын мэдээллийг тогтмол улирал, тутам нэгтгэж, нийтэллээ. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1.6 дахь заалт | олон нийтийн мэдээллээр хангаж байгаа | 100% Хэрэгжсэн |
| 3. | 3. | | 8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | БОНБТХОХэлтэс | | | |
| 4. | 4. | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг | 5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно. (5.2.Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Отгонтэнгэр-Оргил ХХК-д Салбарын Ерөнхий байцаагчийн баталсан | Орхон аймгийн Засаг даргын 2025оны А/131 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 14 компаний 21 тусгай зөвшөөрлийн талбайг газар | Техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээг Монгол улсад эрх авсан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдээр хийлгэж | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хориглох тухай 2009-07-16 | нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.) | удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж илэрсэн дутагдалтай холбогдуулан улсын ахлах байцаагчийн 7 заалттай хугацаатай албан шаардлага өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 500 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Отгонтэнгэр-Оргил ХХК-д гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж ажиллахад ТЭЗҮ, БОНБНҮ-ний тайланг 2025 оны 12 дугаар сард хурлаар орохоор материалаа БОУАӨЯ-д хүргүүлсэн байна. Албан шаардлагаар өгсөн үүрэг даалгавар 70 хувийн биелэлттэй байна. Олборлолтод өртсөн 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2026 оны хавар биологийн нөхөн сэргээлт болгож актаар хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Орхон аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах зорилго чиглэлтэй “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” ТББ үйл ажиллагаагаа хэвийн явуулж Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын талаар олон нийтэд сурталчилан ажиллаж байна. | дээр нь үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж ажиллахад Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Отгонтэнгэр-Оргил ХХК нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34.5.1,Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7,3,9,1,34 дүгээр заалтуудыг удаа дараа зөрчиж байгаа тул ажлын хэсгийн даргын гарын үсэгтэй хугацаатай албан мэдэгдэл Улсын ахлах байцаагчийн 7 заалттай албан шаардлага өгсөн. | 2025 оны 12 дугаар сард хурлаар орохоор материалаа БОУАӨЯ-д хүргүүлсэн байна. | |
| **Хэсгийн дундаж хувь: 90%** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2. УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ-7** | | | | | | | |
| 5. | 1. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай **№2025_04, 2025-06-10** | 1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | Байгаль орчны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хууль тогтоомжийг эрчимжүүлэх зорилгоор улирал тутам буюу 3 удаа нийт 7.128.000 төгрөгийг урамшуулалд олголоо. | Ёс зүйн дэд хороо 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэн ажилласан. | Албан хаагчдын харилцаа хандлагад эерэг нөлөө үзүүлнэ. | 100% Хэрэгжсэн |
| 6. | 2. | | 1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны хараат бус, бие даасан байдлыг хангахын тулд улс төрөөс ангид, мэдээлэлд нэвтрэх эрх, шийдвэр гаргахдаа нөлөөнд автахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах зэргийг харгалзан ТЖАХ-ын төлөөллөөс хамт олны хурлын шийдвэрээр томилж ажилласан. | Байгаль орчны газрын ёс зүйн зөвлөлийн 2025 оны<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Ёс зүйн үйл ажиллагааны шударга байдал, үр нөлөөг нэмэгдүүлж, төрийн байгууллагад ил тод, хариуцлагатай соёлыг төлөвшүүлэнэ. | 100% Хэрэгжсэн |
| 7. | 3. | | 1.1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах; | Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын дагуу Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллалаа. | Байгаль орчны газрын ёс зүйн зөвлөлийн 2025 оны<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мөн байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үйл ажиллагааны чиглэлээр 8 арга хэмжээ, сургалт нөлөөллийн чиглэлээр 4 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. | | | |
| 8. | 4. | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай **№2024-06 ЁЗДБХ, 2024-11-06** | 1.3. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Байгууллагын төрийн захиргааны 11 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан нийт 16 албан хаагч, ажилтан ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм, стандартыг сурталчилж, сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тус байгууллагад ёс зүйн болон захиргааны зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй болно. Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” сэдэвт хойд бүсийн зөвлөгөөний Ёс зүйн дэд хороодыг чадавхижуулах салбар сургалтад хамрагдлаа.<br>-Байгууллагын ёс зүйн дэд | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах | Албан хаагчдын ажилдаа хандах хандлагад эерэг нөлөө үзүүлнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хороо, Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын соёл, үнэт зүйл, байгууллагын хөгжилд хувь хүний хандлага хэрхэн нөлөөлхийг таниулах зорилгоор “Байгууллага дахь хувь хүний хандлага”, “Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй” сэдэвт 2 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг нийт албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа. | | | |
| 9. | 5. | | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үйл ажиллагааны чиглэлээр 8 арга хэмжээ, Сургалт, нөлөөллийн чиглэлээр 4 арга хэмжээг төлөвлөн батлуулж Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооны цахим системд байршуулж ажиллалаа. | Байгаль орчны газрын ёс зүйн зөвлөлийн<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлнэ. | 100%<br>Хэрэгжсэн |
| 10. | 6. | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>**№03, 2023-01-17** | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас EIC.mn мэдээллийн санд орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон байгаль орчны мэдээлийг бүртгэх, шинэчлэх ажлын чиглэл ирээгүй байна. | - | - | - |
| 11. | 7. | "Монгол Улсын | 1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв | Байгаль орчинд нөлөөлөх | БОУАӨЯ-ны цахим | Байгаль орчинд | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай"<br>**№01, 2022-01-17** | ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох; | байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг И-Монголиа цахим системд шилжүүлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын дагуу 2025 оны жилийн<br>эцсийн байдлаар шинээр хэрэгжих болон хэрэгжиж буй нийт 37 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, тус төслүүдийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэн БОУАӨЯ-ны цахим мэдээллийн санд оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллалаа. | мэдээллийн санд оруулах. | үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна | Хэрэгжсэн |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | |
| **3. УИХ-ЫН ТОГТООЛ-3** | | | | | | |
| 12. | 1. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай<br>**№2024-24, 2024-04-18** | 2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллалаа.<br>Мөн байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үйл ажиллагааны чиглэлээр 8 арга хэмжээ, сургалт | Байгаль орчны газрын ёс зүйн зөвлөлийн 2025 оны<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлнэ. | 100%<br>Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | нөлөөллийн чиглэлээр 4 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. | | | |
| | 2. | Засгийн газарт чиглэл өгөх тухай **2025-06-05 Дугаар 2025 №53** | 1.6/. 6/агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, (олон нийтийн радио, телевизийн цаг агаарын мэдээтэй хамтатган Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлын хэмжээг мэдээлэх) зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх | Эрдэнэт хотын хэмжээнд Говил багийн нутаг дэвсгэрт болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр суурилуулсан тоосны автомат 2 станцын хэмжилтийн дүн мэдээг www.Agaar.mn-д оруулж, иргэдийг мэдээ мэдээллээр тогтмол хангаж байна. | - | Агаарын чанарын мэдээ мэдээлэл тогтмол нээлттэй болно. | 100% Хэрэгжсэн |
| | 3. | | 1.3/. 3/агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж, тухайн бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх | Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмыг БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/441/ А/724 дугаар тушаал, захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журам | Эх үүсвэрийн тоо буурна | 100% Хэрэгжсэн |
| **4.ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ** | | | | | | | |
| 13 | 1. | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ **№58, 2021-10-04** | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Бүх нийтээр мод тарих хаврын ажлыг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж, "Өрх бүр 5 ш мод" 121 өрхөд 10.406 ширхэг модны тарьц, суулгацын дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас зохион байгуулсан "Хашаандаа 5 мод тарья" аянд тус аймгийн 5 аж ахуйн | байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.5 дахь заалтад тусгасан | 429457 ширхэг мод тарьсан | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгж байгууллага оролцож, 240 өрх, 1 байгууллагын хашаанд 1400 ширхэг мод тарилаа. | | | |
| 14. | 2. | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгээр боловсруулах Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, аргачлал, технологийн нэгдсэн зөвлөмжийн дагуу тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажилд модны төрөл, зүйлийг тохируулан ажиллаж байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.5 дахь заалтад тусгасан | 27 зүйлийн мод тарьсан | 100% Хэрэгжсэн |
| 15. | 3. | | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр мод тарих, таримал ойг хамгаалах, ойн зурвас байгуулах, голын татмын ойжуулалт хийх зэрэг 440.35 сая төгрөгөөр 5 арга хэмжээнд шинээр хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүллээ. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.5 дахь заалтад тусгасан. | 440.35 сая төгрөг тусгасан | 100% Хэрэгжсэн |
| 16. | 4. | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй | Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Ар булаг, Жаргалант сумын Зүүн булаг | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.2, 1.2.5, 1.2.10 дахь заалтуудад тусгасан | 2 булгийн эхийг тохижуулсан | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | зэрэг гадаргын усны эх ундаргыг хамгаалж, саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд талуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилгоор аймгийн Байгаль орчны газар, “Галсэнтий” ХХК хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулж, таримал мод услахад ашиглаж эхлэлээ. | | | |
| 17. | 5. | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулж, төрийн 61 байгууллага, Эрдэнэт үйлдвэрийн цех нэгжийн 15.0 мянга гаруй ажилтан, албан хаагчдыг татан оруулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээлээ. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.1 дэх заалтад тусгасан | 3.1 га талбайд нийтийн эзэмшлийн ногоон байгууламж байгуулсан | 100% Хэрэгжсэн |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | | |
| **ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ-1** | | | | | | | |
| 18. | 1. | Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64 **№Дугаар 20, 2025-08-13** | 5.Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан инфографик, нийтлэл, зурагт хуудас мэдээллийг байгууллагын цахим хуудас, байгууллагын пэйж хуудсаар 2 удаа нийтлэх ажлыг нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Авлигын эсрэг хууль, | | Албан хаагчдыг | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 2025 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 5 албан хаагчийн мэдээллийг аймгийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний дагуу Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан 2025 оны ХАСХОМ бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар цахим сургалтад хамруулллаа. | | | |
| | | | | | | | |
| **5. ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР-18** | | | | | | | |
| 18. | 1. | Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай **№2025-04, 2025-07-25** | 1.7. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн засаг | МУ-ын Засгийн газрын 2024 оны 06 дугаар “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолын 6 дугаар хэсэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 02/4434 тоот албан бичиг, Орхон аймгийн Засаг даргын 2024 оны А/691 дүгээр “Байгаль орчны газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах | | Албан хаагчдын мэргэшсэн тогтвортой байдал хангагдана. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19. | 2. | | дарга, засгийн газрын агентлагийн дарга нарт; 1.4. Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад; | тухай" захирамжаар тус газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэрийг гаргаагүй. Байгаль орчны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. | Байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын албан хаагчдын сахилга бат, байгууллагын соёл, ил тод, нээлттэй байдал нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |
| 20. | 3. | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай **№2025-03, 2025-07-08** | 5. Энэ албан даалгаварын хэрэгжилт үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр ЗГХЭГ-т ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, биелэлтэд хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын ларга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | - | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлага сайжирна. | 100% Хэрэгжсэн |
| 21. | 4. | | 4.4. Ажилтны мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. | Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг Дотоод сургалтын чиглэлээр 6 арга хэмжээ, олон нийтэд сургалт зохион байгуулах чиглэлээр 3 арга хэмжээ, сурталчилгааны чиглэлээр 5 арга хэмжээг төлөвлөж, газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Удирдлагын академын Төрийн албаны сургуулийн төрийн албан хаагчийн | Сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. | Ажилтны мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагчийг суралцуулахаар саналыг аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсний дагуу 1 албан хаагчийг улсын зардлаар суралцууллаа. | | | |
| 22. | 5. | | 3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой хээрийн түймэр, хүн малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх. | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн захиргааны байгууллагуудтай хамтарсан болон байгаль хамгаалагчийн өдөр дутмын эргүүл, хяналт шалгалтыг 63 хоногийн хугацаанд зохион байгуулж 900 гаруй иргэн 33 ААНБ-д, 26 малчин өрх, 14 ойн нөхөрлөлд 832 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шинэчилсэн гарын авлага түгээж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн Газраас хэрэгжүүлж байгаа “Ойн түймэртэй тэмцэх, чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд 16 ойн нөхөрлөлд 7 төрлийн 55 ширхэг ой, хээрийн түймэр унтраах багаж, анхны тусламжын хэрэгслийг олгож, дэмжлэг үзүүлж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-д | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.4 дэх заалт | Ойн түймэр бүртгэгдээгүй | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | танилцуулж, аймгийн хэмжээнд 2026 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2025 оны 03/51 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажилллаа. | | | |
| 23. | 6. | | 2.33. төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулалан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн хороодыг байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан инфографик, нийтлэл, зурагт хуудас мэдээллийг байгууллагын цахим хуудас, байгууллагын пэйж хуудсаар 2 удаа нийтлэх ажлыг зохион байгууллаа.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 2025 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 5 албан хаагчийн мэдээллийг аймгийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний дагуу Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан 2025 оны ХАСХОМ бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар цахим сургалтад хамрууллаа.<br>Байгаль орчны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаар тушаалаар Ёс зүйн | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.8, 3.1.10 дахь заалт | Байгууллагын албан хаагчдын сахилга бат, байгууллагын соёл, ил тод, нээлттэй байдал нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. Байгууллагын төрийн захиргааны 11 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан нийт 16 албан хаагч, ажилтан ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм, стандартыг сурталчилж, сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад ёс зүйн болон захиргааны зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй болно. Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үйл ажиллагааны чиглэлээр 7 арга хэмжээ, Сургалт, нөлөөллийн чиглэлээр 3 арга хэмжээг төлөвлөн батлуулж Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооны цахим системд оруулж ажиллалаа.<br>- Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” сэдэвт хойд бүсийн зөвлөгөөний Ёс зүйн дэд хороодыг | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | чадавхижуулах салбар сургалтад хамрагдлаа.<br>-Байгууллагын ёс зүйн дэд хороо, Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын соёл, үнэт зүйл, байгууллагын хөгжилд хувь хүний хандлага хэрхэн нөлөөлхийг таниулах зорилгоор “Байгууллага дахь хувь хүний хандлага”, “Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй” сэдэвт 2 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг нийт албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа. | | | |
| 24. | 7. | | 2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох мэдээлэл байхгүй болно. | - | - | 100% Хэрэгжсэн |
| 25. | 8. | | 1.6. төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томиололтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд тус байгууллагад гадаад албан томилолтод зарцуулсан зардал байхгүй. ИТХ-аар 2025 оны дотоод албан томилолтын төсөвт 7.192.000 төгрөг батлагдсанаас 5.190.000 төгрөгийг дотоод албан томилолтод зарцуулж 2.002.000 төгрөг хэмнэн ажиллалаа.<br>Тухайн онд байгууллагын урсгал зардалаар олон нийтэд чигэлсэн арга хэмжээ зохион байгуулаагүй хуулийн | - | Хуулийн хэрэгжилт сайжирна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2025 оны байгууллагын батлагдсан төсөв 859,300.6 мянган төгрөг үүнээс 12 сарын 09-ний байдлаар 672,960.3 мянган төгрөгийг зарцуулж 186,340.35 төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. | | | |
| 26. | 9. | | 1.2. Харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх | Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар 02 -ны өдрийн А/691 дүгээр захирамжаар Байгаль орчны газрын бүтэц орон тоог Төрийн захиргааны-12, Төрийн үйлчилгээний-5 нийт 17 орон тоотойгоор баталсан боловч 1 албан хаагчийн сул орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган зорилгоор чиг үүргийн шинжилгээг хийж ТАЗСЗ-д хүргүүлэн ажилласан. | Орхон аймгийн байгаль орчны газрын<br>Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байранд шинжилгээ хийх. | Албан хаагчдын ажлын ачаалал, давхардал хийдэл арилна. | 100% Хэрэгжсэн |
| 27. | 10. | | 1.11 Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх. | Цахим шилжилтийг эрчимжүүлэн хүнд суртал, шат дамжлагыг бууруулах, цаг хугацаа, цаас хэмнэх зорилгоор и-монголиа цахим системийн Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системээр аж ахуйн нэгжээс 17 хүсэлт, иргэнээс 12 хүсэлт, нийт 29 хүсэлт ирсэнээс 3 хүсэлтэд татгалзаж, 26 хүсэлтийг шийдвэрлэж ажиллалаа. | - | Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна. | 100% Хэрэгжсэн |
| 28. | 11. | Төрийн албаны | 3.2. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр | Аймгийн Засаг даргын шуурхай хурлаас 2025 оны | Үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь тогтмол | Төрийн албаны сахилга, дэг журам, | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай **№2025-01, 2025-06-18** | дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох; | жилийн эцсийн байдлаар 38 үүрэг даалгавар өгснийг албан хаагчдад мэдээлж, биелэлтийг тогтоосон хугацаанд биелүүлэхэд онцгой анхааран 97.9% биелүүлж ажиллалаа. | шийдвэрлэж системд оруулах. | хариуцлага сайжирна. | |
| 29. | 12. | | 2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд тус байгууллагад гадаад албан томилолтод зарцуулсан зардал байхгүй. ИТХ-аар 2025 оны дотоод албан томилолтын төсөвт 7.192.000 төгрөг батлагдсанаас 5.190.000 төгрөгийг дотоод албан томилолтод зарцуулж 2.002.000 төгрөг хэмнэн ажиллалаа.<br>Тухайн онд байгууллагын урсгал зардалаар олон нийтэд чигэлсэн арга хэмжээ зохион байгуулаагүй хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2025 оны байгууллагын батлагдсан төсөв 859,300.6 мянган төгрөг үүнээс 12 сарын 09-ний байдлаар 672,960.3 мянган төгрөгийг зарцуулж 186,340.35 төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. | - | Хуулийн хэрэгжилт сайжирна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30. | 13. | | 1.2. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах. | Байгууллагын төрийн захиргааны 11 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан нийт 16 албан хаагч, ажилтан ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж соёл, дэг журам, дүрэм, заавгыг чанд баримтлан, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм, стандартыг сурталчилж, сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад ёс зүйн болон захиргааны зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй болно. | Ёс зүйн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх | Байгууллагын албан хаагчдын сахилга бат, хариуцлагатай байдал нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |
| 31. | 14. | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай **№2025-03, 2025-03-07** | 1.14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчилж ургуулах ажлыг эрчимжүүлэх; | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих Хавар намрын өдрүүд болон зуны мод тарилтаар төрийн болон хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор олон талт арга хэмжээ зохион байгуулж, 8 байршилд 429.5 мянган ширхэг мод тарьж, Ногоон Эрдэнэт хөтөлбөр эхлэснээс хойш өссөн дүнгээр 5.26 сая ширхэг мод тарилаа. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1 дэх зорилт | Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн | 100% Хэрэгжсэн |
| 32. | 15. | | 1.15. Хот, суурин газрын хог хаягдлын менежментийг төр-хувийн хэвшлийн оролцоотой сайжруулах, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх; | Орхон аймгийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах, ачилт, тээвэрлэлт, дарж, устгалын хүчин чадлыг сайжруулах | АЗДҮАХ-ийн 3.6.1.4.4, 3.6.1.4.5 дахь заалт | Хог хаягдлын менежментийг сайжруулахад төр, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зорилгоор 2022-2024 онд орон нутгийн төсвийн 5.68 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг 90%-д хүргэснээр хог хаягдлын татан авалтыг 3-4 удаагийн давтамжаар нэмэгдүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 120 тн хог хаягдлыг цуглуулан төвлөрүүлж, Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан.<br>“Зэс эрдэнийн хувь” ХХК ажилчидын хоргүйжүүлэх бүтээгдэхүүний сав, баглаа боодол болох 96 кг хуванцар савыг “Витафит” ХХК-д, 8400ш/1.43тн/ артишокны шилийг “Газар шим” ХХК-д буцаан тушаасан.<br>Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 10 үйлдвэр, ААНБ-ын 573.291тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуйг ангилан ялгаж, тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэн устгуулсан байна.<br>Мөн ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг Элемент ХХК-д шилжүүлэн өгч устгуулаа.<br>Нийт 121.526тн энгийн, 573.6 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуйг тус тус ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна. Орчны бүсийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, ажлын хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй 27 ААНБ-уудын 713 ажилчдыг хамруулан 2025 оны 05 сарын 19-өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд зохион байгуулж, нийт 32 цэгт хуримтлагдсан 650$м^3$ эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, дарж устгууллаа. | | | |
| 33. | 16. | | 1.16. Саарал усны хэрэглээ, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх; | Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 3.6.1.2.4 дэх арга хэмжээ (Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих)-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд бодлогын байгууллагын дэмжлэгтэйгээр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд талуудын оролцоо, санаачлагыг дэмжих зорилгоор аймгийн Байгаль орчны газар, Галсэнтий ХХК хамтарч ус цэвэршүүлэх технологийг | Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих зардал | 6 байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн лабораторит баталгаажуулсан саарал усыг барилга, автомашин угаалга, мод усалгаа, ноос угаах салбарт нэвтрүүлж эхлэн, саарал ус нийлүүлэгч Галсэнтий ХХК, бие даасан саарал усны технологи суурилуулсан иргэн Ч.Өлзийнаран, зөөврөөр саарал ус ашигласан Хурд, Лайк, Монбет, Сархиа зэрэг автомашин угаалгын газруудыг бодлогоор дэмжих ажлыг зохион байгууллаа. | | | |
| 34. | 17. | | 1.17. Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох төсөл хэрэгжүүлэх; | -Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 8 байршилд цахилгаан дамжуулах дэд станцууд шинээр барьж, 380 айлын цахилгааны уналтыг шийдвэрлэсэн.<br>-Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулллаа.<br>-“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт | АЗДҮАХ-ийн 3.6.1.4.3 дахь заалт | Эх үүсвэрийн өөрчлөлтийг тодорхойлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн хүртээмж нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөл авах ажлууд 100% хэрэгжилттэй. Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар "Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж, Эдийн засгийн форумд танилцуулж, 2026 оны төсөвт 2.2 тэрбум төгрөгийн саналыг оруулллаа. | | | |
| 35. | 18. | | 1.24. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах; | МУЕС-ын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд: -Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж, 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамруулллаа. Тайлант хугацаанд 15338.2 тн нүүрс, 49457 $м^3$ мод түлшинд зарцуулсан байна. Орхон аймгийн хэмжээнд саарал усыг бетон зуурмаг, зам усалгаа, барилга, автомашин угаалга, мод усалгаа, ноос угаах салбарт | -Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулах. -Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих | -мэдээллийн сан шинэчлэгдэнэ. - 6 газарт бодлогын дэмжлэг үзүүлсэн | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэвтрүүлж эхлэн, идэвхи санаачлагатай ажиллаж буй газруудыг аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/893 тоот захирамжийн хүрээнд бодлогоор дэмжих-урамшуулах ажлыг хамтран зохион байгуулж, 6 газарт нийт 27 сая.төг-ийн дэмжлэг үзүүллээ. | | | |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | | |
| **6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ-14** | | | | | | | |
| 36. | 1. | Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл **№26, 2025-11-05** | 7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав. | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд тус байгууллагад гадаад албан томилолтод зарцуулсан зардал байхгүй. ИТХ-аар 2025 оны дотоод албан томилолтын төсөвт 7.192.000 төгрөг батлагдсанаас 5.190.000 төгрөгийг дотоод албан томилолтод зарцуулж 2.002.000 төгрөг хэмнэн ажиллалаа.<br>Тухайн онд байгууллагын урсгал зардалаар олон нийтэд чигэлсэн арга хэмжээ зохион байгуулаагүй хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2025 оны байгууллагын батлагдсан төсөв 859,300.6 мянган төгрөг үүнээс 12 сарын 09-ний байдлаар 672,960.3 мянган төгрөгийг зарцуулж 186,340.35 төгрөгийн хэмнэлттэй | - | Хуулийн хэрэгжилт сайжирна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллаж байна. | | | |
| 37. | 2. | | 1.2. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаварын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх. | Монгол Улсын хууль, тогтоомжийн хэрэгжилт, БОУАӨЯ-нд Орхон аймгийн байгаль орчны газрын байцаагчдын өргөдөл, гомдлын дагуу шийдвэрлэлтийн тайлан, Байгууллагын сар бүрийн онцлох ажлууд зэрэг тайлан мэдээг гаргаж холбогдох дээд газруудад сар бүр хүргүүлэн ажиллалаа. | Сар бүр тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлэх. | Хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирна. | 100% Хэрэгжсэн |
| 38. | 3. | | 1.1. Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах" тухай 01 дүгээр, "Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар, "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар, "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавараар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | - | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлага сайжирна. | 100% Хэрэгжсэн |
| 39. | 4. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл **№2025_15, 2025-09-02** | 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн, зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу boajg.or.gov.mn цахим мэдээллийн хуудсанд байгууллагын “Орхон аймгийн Байгаль орчны газар” олон нийтийн цахим мэдээллийн хуудсыг нэгтгэж, тогтмол шинэчлэх нөхцлийг бүрдүүллээ. Мөн shilen.gov.mn, gov.mn, зэрэг цахим мэдээллийн санд байгууллагын мэдээллийг тогтмол улирал | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.16 дахь заалт “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу shilen.gov.mn, gov.mn, boajg.or.gov.mn зэрэг цахим мэдээллийн санд салбарын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн тусгах.” | Иргэдийг мэдээ, мэдээллэжр шуурхай хангана. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тутам нэгтгэж, 3 удаа нийтэллээ. | | | |
| 40. | 5. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл **№2025_13, 2025-08-20** | 2.3.2.10.. шахмал түлшний стандартыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх, шахмал түлшний хэрэглээний гадаад, дотоод орчны агаарын чанар, стандартад үзүүлж байгаа нөлөөллийг тогтмол хянах арга хэмжээ зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | - | - | - | - |
| 41. | 6. | | 12.3.2.9.. гэр, барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч, агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулллаа. “Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна. | Монгол гэрийн дулаалга, халаалтын багц бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэнй нөхцлөөр олгох. ИШСүлжээг өргөтгөх, иргэдийн хэрэглээнд ойртуулах. | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо буурна. | 100% Хэрэгжсэн |
| 42. | 7. | | 12.3.2.7.. агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн сувгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн | Эрдэнэт хотын хэмжээнд Говил багийн нутаг дэвсгэрт болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр суурилуулсан тоосны автомат 2 станцын хэмжилтийн дүн мэдээг | - | Агаарын чанарын мэдээ мэдээлэл тогтмол нээлттэй болно. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | www.Agaar.mn-д оруулж, иргэдийг мэдээллээр хангаж байна. | | | |
| 43. | 8. | | 12.3.2.6. Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн гэр хорооллын өрх бүрд байршуулж, хяналт тавин, мэдрэгч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 2022 онд ОББҮХ-ны хөрөнгө оруулалтаар Орхон аймагт 1100 ширхэг угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн бөгөөд угаарын хийн хяналтын төвийг шинээр байгуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, программ хангамжийн зардал шийдвэрлэгдээгүйн улмаас тухайн угаарын хийн мэдрэгчийг айлуудад суурилуулаагүй, түр хадгалагдаж байна. | - | - | - |
| 44. | 9. | | 12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус; | Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчилж, БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан А/441/А/724 тоот тушаал, захирамжаар батлуулж, мөрдөн ажиллаж байна. Тоосжилт ихтэй бүс болох Говил багийн “Эрх-бужинхэн” цэцэрлэг, багийн байруудын цонхны салхивчинд нарийн ширхэгт PM2.5 тоос, тоосонцор, хорт утааны нано шүүлтүүр суурилуулах ажлыг Орхон аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан | Орхон аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө | Дотоод орчны агаар сайжирна | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллаж байна. | | | |
| 45. | 10. | | 12.3.2.2.. нийслэл, төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг 3 жилийн дотор Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | -Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж, 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамрууллаа. Тайлант хугацаанд 15338.2 тн нүүрс, 49457м$^3$ мод түлшинд зарцуулсан байна.<br>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 8 байршилд цахилгаан дамжуулах дэд станцууд шинээр барьж, 380 айлын цахилгааны уналтыг шийдвэрлэсэн.<br>Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг буурууллаа.<br>“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4.8, 1.5.4 дэх заалтууд | Эх үүсвэрийн өөрчлөлтийг тодорхойлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн хүртээмж нэмэгдэнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар “Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж, Эдийн засгийн форумд танилцуулж, 2026 оны төсөвт 2.2 тэрбум төгрөгийн саналыг оруууллаа. | | | |
| 46. | 11. | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл<br>**№44, 2024-12-18** | 44.22.1.12. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, холбогдох албадын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | -Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж, 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамруулллаа. Тайлант хугацаанд 15338.2 тн нүүрс, 49457 $м^3$ мод түлшинд зарцуулсан байна.<br>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 8 байршилд цахилгаан дамжуулах дэд станцууд шинээр барьж, 380 айлын цахилгааны уналтыг шийдвэрлэсэн.<br>Монгол гэрийн дулаалга, | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4.8, 1.5.4 дэх заалтууд | Эх үүсвэрийн өөрчлөлтийг тодорхойлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн хүртээмж нэмэгдэнэ. | 100%<br>Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг буурууллаа.<br>“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар “Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж, Эдийн засгийн форумд танилцуулж, 2026 оны төсөвт 2.2 тэрбум төгрөгийн саналыг орууллаа. | | | |
| 47. | 12. | Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл **№2024-31, 2024-09-04** | 31.9.6. 2/ Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу boajg.or.gov.mn цахим мэдээллийн хуудсанд байгууллагын “Орхон аймгийн Байгаль орчны газар” олон нийтийн цахим мэдээллийн хуудсыг нэгтгэж, тогтмол шинэчлэх нөхцлийг бүрдүүллээ.<br>Мөн shilen.gov.mn, gov.mn, зэрэг цахим мэдээллийн санд байгууллагын | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1.6 дахь заалт | Нийтийг мэдээллээр хангасан. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийг тогтмол улирал, хагас жилээр нэгтгэж, нийтэлж, өрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудастай нэгтгэлээ. | | | |
| 48. | 13. | 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл **№51, 2023-12-13** | XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | БОУАӨЯамны салбарын хяналтын газрын ерөнхий байцаагчийн баталсан “Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх 01/06 дугаартай удирдамжийн хүрээнд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 51 обьектыг хамруулан гүйцэтгэлээ. Тус шалгалтаар нүхэн жорлон ашиглаж байсан 11 үйлчилгээний газарт улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн 11 объектын нүхэн жорлонг буулгуулж шинээр стандарт, шаардлага хангасан био болон төвийн шугамд холбогдосон ариун цэврийн байгууламжаар шинэчлүүлсэн. Мөн энгийн болон аюултай хог хаягдлын хадгалалт, устгалын үйл ажиллагаатай холбоотой илэрсэн дутагдлыг арилгуулхаар 21 объектод 45 зааалттай албан шаардлага хүргүүлж, Хог хаягдлын тухай хууль зөрчсөн 9 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.2 дахь заалт Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол багасч, иргэн, ААНБ-уудын хариуцлага сайжирна. | Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол багасч, иргэн, ААНБ-уудын хариуцлага сайжирна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлчилгээний газар, 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 2.800.000 төгрөгний торгууль ноогдуулан ажиллалаа. Шалгалтын мөрөөр хүргүүлсэн албан шаардлагын гүйцэтгэлд хяналт хийхэд 45 заалтаас 39 заалт хангагдаж шалгалтад хамрагдсан нийт объектын хууль сахин мөрдөлтийн түвшин буюу хууль тогтоомжийн хэрэгжилт 86 хувьтай байна. | | | |
| 49. | 14. | 2023_18. 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл / 2023-04-26 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл **№2023-18, 2023-04-26** | XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн захиргааны байгууллагуудтай хамтарсан болон байгаль хамгаалагчийн өдөр дутмын эргүүл, хяналт шалгалтыг 63 хоногийн хугацаанд зохион байгуулж 900 гаруй иргэн 33 ААНБ-д, 26 малчин өрх, 14 ойн нөхөрлөлд 832 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шинэчилсэн гарын авлага түгээж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн Газраас хэрэгжүүлж байгаа “Ойн түймэртэй тэмцэх, чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд 16 ойн нөхөрлөлд 7 төрлийн 55 ширхэг ой, хээрийн түймэр унтраах | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.4 дэх заалт | Ойн түймэр бүртгэгдээгүй | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | багаж, анхны тусламжын хэрэгслийг олгож, дэмжлэг үзүүлж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-д танилцуулж, аймгийн хэмжээнд 2026 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2025 оны 03/51 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажилллаа. | | | |
| | 15. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл | 16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх; | Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем (system.gov.mn)-д бүртгүүлэх санал хүргүүлсэн болно. | Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем (system.gov.mn)-д холбогдох мэдээллийн нийтлэхээр төлөвлөж байна. | - | - |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | | |
| **7.ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ, ТЭМДЭГЛЭЛ-5** | | | | | | | |
| 50. | 1. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнии тухай **№01, 2022-05-02** | 1.3 . Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгаи зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэи болон хяэгаарлагдмал/ зохион баигуулах тусгаи зөвшөөрлийн талбаин хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх; | БОНХОБТХ | | | - |
| 51. | 2. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор | Бүх нийтээр мод тарих намар, хаврын ажлын хүрээнд үндсэн 2 арга хэмжээг зохион байгуулж, 14 байршилд олон нийтийн оролцоотой болон хөрөнгө | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1 дэх зорилт | Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай<br>**№03, 2021-09-30** | экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | оруулалттай ажил хийж 429.457 ширхэг мод тарилаа. Мөн мод бут сөөг тарьц суулгац тарих хүсэлтэй иргэд олон нийтийг тарьц суулгацаар хангах зорилгоор мод, бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 34058 борлуулагдаж, нийтийн мод тарих ажлыг зохион байгуулагдсан газруудад хар шорооны болон цэнэг усалгааны нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. | | | |
| 52. | 3. | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай **№60/40, 2019-12-31** | 2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ус хангамжийн цех нь 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 96 169 890м3 эргэлтийн усыг хаягдлын аж ахуйн далангаас ашигласан байна. | Хаягдлын аж ахуйн бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах | Эргэлтэд оруулсан усны хэмжээ өмнөх оныхоос 3.967 сая.м3 буюу 5 хувиар нэмэгдсэн байна. | 100% Хэрэгжсэн |
| 53. | 4. | | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого, судалгааны ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж нийт 14194 нүхэн жорлонг бүртгэлжүүлж, 2028 он хүртэл нүхэн жорлонгийн тоог 20%-иар бууруулах төлөвлөгөө гарган баталгаажуулж, БОУАӨЯ-нд хүргүүллээ.<br>Тооллогоор бүртгэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эзэмшлийн 11 нүхэн жорлонг өөрчлүүлэхээр Байгаль | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4.5 дахь зорилт | Нүхэн борлонгийн тоо буурна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | орчны хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагуудыг хүргүүлж, шийдвэрлүүллээ.<br>“Гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэх” БОАЖЯ/202202080 тоот гэрээний дагуу Баян-Өндөр сумын Даваат, Шанд багт Н ЭЙ БИ ХХК-ийн хэрэгжүүлсэн 1000 эко ариун цэврийн байгууламж барих ажлын дутуу хийгдсэн 275 айлын бүхээгийн ажлыг гүйцэтгүүлж, бүрэн хүлээн авлаа.<br>Нийтийн эзэмшлийн талбайд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт голын голдирол дагуу Цэнгэлдэх хүрээлэнгийн ар талд нэг дор 6 хүн үйлчлүүлэх хүчин чадалтай нийтийн ариун цэврийн байгууламжийг барьж, ашиглалтанд орууллаа. | | | |
| 54. | 5. | Нийслэлийн агаар орчны бохирдолын тухай<br>**№03/03, 2017-03-03** | Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Аймгийн хэмжээнд агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр бодлогын 3 бичиг баримтийг батлан хэрэгжүүлж байгаа ба шинээр Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар “Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4.8 дахь зорилт | Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнд эх үүсвэрийн тоо буурч, орчны чанар сайжирна. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | чиглэлийн 24 төсөл бичиж, Эдийн засгийн форумд танилцуулж, 2026 оны төсөвт 2.2 тэрбум төгрөгийн саналыг оруулллаа.<br>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 8 байршилд цахилгаан дамжуулах дэд станцууд шинээр барьж, 380 айлын цахилгааны уналтыг шийдвэрлэсэн.<br>Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулллаа.<br>“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна. | | | |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | | |
| **8.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ-15** | | | | | | | |
| 55. | 1. | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 01-ний | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 11 | - | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлнэ. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай<br>**№147, 2025-10-29** | өдөр хүртэлх хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насний хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа, ажил хөдөлмөр эрхэлдэг эх, эцэг, асран хамгаалагчид ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга захирал, нарт даалгаж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажил олгогч нарт уриалсугай. | дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0-6 настай хүүхэдтэй 3 албан хаагчид 5 хоногийн цалинтай чөлөөг олгож ажилласан. | | | |
| 56. | 2. | Зорилт шинэчлэн батлах тухай<br>**№91, 2025-09-10** | 3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Аймгийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг бодитой тогтоох зорилгоор нэгдсэн тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр 2026 оны төлөвлөгөөнд тусгаж, шаардлагатай зардлыг Байгаль хамгаалах арга хэмжээний зардлыг батлууллаа.<br>-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, 8 байршилд 429.5 мянган ширхэг мод тарьж, Ногоон Эрдэнэт хөтөлбөр эхлэснээс хойш өссөн дүнгээр 5.26 сая ширхэг мод тарилаа.<br>-Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ар булаг, Жаргалант сумын Зүүн булгийн эх орчмыг усны тэжээгдлийн бүсээр нь бүрэн хамгаалах, нөхөн сэргээх ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлж, сумдын ЗДТГ-т хүлээлгэн өглөө. | Тооллого зохион байгуулах. | Хүлэмжийн хийн ялгарлын эх үүсвэр, хэмжээ тогтоогдоно. | 100%<br>Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Эрдмин ХХК нь Хүрэнбулгийн хамгаалалтыг сайжруулах ажлыг өөрсдийн зардлаар гүйцэтгүүллээ. | | | |
| 57. | 3. | Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай **№2025_279, 2025-06-04** | 1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай. | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдын амарсан 2 өдрийг газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 4, 5 -ны өдөр нөхөж ажиллалаа. | - | - | 100% Хэрэгжсэн |
| 58. | 4. | Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай **№2025_242, 2025-05-21** | 2.Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | - | - | - | - |
| 59. | 5. | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай №226, 2024-12-20 | 4. 4. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга С.Одонтуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 8 байршилд цахилгаан дамжуулах дэд станцууд шинээр барьж, 380 айлын цахилгааны уналтыг шийдвэрлэсэн.<br>Монгол гэрийн дулаалга, | Эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол гэрийн дулаалга, халаалтын багц бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгох.<br>ИШСүлжээг өргөтгөх, иргэдийн хэрэглээнд ойртуулах. | Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болно.<br>Эх үүсвэрийн тоо буурна | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тус тус үүрэг болгосугай. | халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг буурууллаа.<br>“Миний гэр бидний гудамж төсөл”-ийн хүрээнд 7 багт ИШС татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар “Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж, Эдийн засгийн форумд танилцуулж, 2026 оны төсөвт 2.2 тэрбум төгрөгийн саналыг орууллаа. | | | |
| 60. | 6. | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай<br>№217, 2024-12-18 | 2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | Байгууллагын boajg.or.gov.mn цахим мэдээллийн хуудсыг үндэсний дата төвийн цахим санд байгуулж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, гүний ус ашиглахтай холбогдсон дүгнэлт зөвшөөрөл, дүгнэлт зэрэг 3 төрлийн үйлчилгээг 26 удаа танилт, нэвтрэлтийн арга хэрэгсэл ашиглан иргэн хуулийн этгээдэд үзүүллээ. | - | Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд, цахимаар түргэн шуурхай үзүүлсэн. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61. | 3. | Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай №2024-163, 2024-11-13 | 2. Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад eoffice.erdenet.mn цахим сүлжээ ашиглан албан бичиг болон тайлан мэдээлэл дамжууллаа, Мөн төрийн захиргааны төв байгууллагуудтай үүсэх харилцааг erp.e-mongolia.mn цахим сүлжээнд бүртгүүлж, албан харилцааг цахимаар холбогдох байгууллагуудтай харилцаж байна. | - | Зарим албан харилцааг цахимаар хэрэгжүүлсэн. | 100% Хэрэгжсэн |
| 62. | 7. | Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай №2024-109-1, 2024-10-02 | 2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай | Байгууллагын дотоод журманд төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тусган газрын даргын 2024 оны А/18 дугаар “Байгууллагын дотоод журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлууллаа. | - | Албан хаагчдын сахилга, хариуцлага дээшилнэ. | 100% Хэрэгжсэн |
| 63. | 8. | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай №196, 2024-05-08 | 3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Шинэчилсэн ХНУМТ цахим системд одоо ажиллаж байгаа 16 албан хаагчдын ажил эрхлэлтийн түүхийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулах, нягтлах /Байгууллагад ажилд авсан түүхийг бүртгэх/, Төрийн албан хаагчийн ангилал зэрэглэл, томилгооны үндэслэлийг оруулах, ажилтныг чөлөөлөх болон томилгооны тушаал шийдвэрүүдийг хавсаргаж албан хаагчдаар өөрсдөөр нь Төрийн цахим үйлчилгээний дан | Ажилтнуудын хувийн хэргийн мэдээ баримтыг байнга шинэчлэн бүрдүүлж, хүний нөөцтэй холбоотой мэдээ, судалгаа тайланг хуулинд заасан хугацаанд мэдээллийн санд оруулж байх. | Албан хаагчид хувийн мэдээллийг цахим системээс шууд татан авах боломж бүрдсэн. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | siситемээр хянуулж баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. | | | |
| 64. | 9. | Техникийн зохицуулалт батлах тухай №148, 2021-05-19 | 2. Агаарын чанарын техникийн зохицуулалтыг 1 дүгээр хавсралт, усны чанарын техникийн зохицуулалтыг 2 дугаар хавсралт, хөрсний чанарын техникийн зохицуулалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай. | Орхон аймгийн хэмжээнд хүрээлэн буй орчны агаар, ус, хөрсний чанарыг УЦУОШТ-ийн БОШЛ нь батлагдсан хөтөлбөрийн дагуу тогтмол хэмжилт, судалгаа хийж, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 148 тогтоолоор батлагдсан агаарын чанарын техникийн 10 шаардлага, усны чанарын 9 шаардлага, хөрсний чанарын 12 шаардлагын хүрээнд хяналт тавин ажиллаж байна. | Батлагдсан хөтөлбөрийн дагуу тогтмол сорьц авч шинжилгээ хийх. | Орчны чанарын өөрчлөлтөд тогтмол хяналт тавина. | 100% хэрэгжсэн |
| 65. | 10. | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай №184, 2020-11-18 | 2. Ойгоос бэлтгэж ашиглах 1 шоометр хэрэглээний мод, түлээнд ногдуулах төлбөрийн хэмжээг 1 дүгээр хавсралт, ойд арчилгааны огтлолт хийх болон ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тогтоосугай. 2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. | Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/11 тоот тогтоолын дагуу Жаргалант сумын ойн сангийн 180 га талбайгаас 900 шоометр мод бэлтгэх эрхийн бичгийг 265 иргэнд олгож, 1.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ. | - | Ойн нөөц ашигласны төлбөрийг бүрэн төвлөрүүллээ. | 100% Хэрэгжсэн |
| 66. | 11. | Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай **№474, 2019-12-25** | 4.. Инженерийн дэд бүтэцтэй болон төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой хот, суурин газарт унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр худаг гаргаж, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт олгохыг хязгаарлах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, | Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай" шийдвэрийн дагуу инженерийн дэд бүтэцтэй болон төвлөрсөн шугам | - | Шугам сүлжээнд холбогдох боломжтой газарт шинээр худаг гаргах зөвшөөрөл олгоогүй. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | сүлжээнд холбогдох боломжтой хот, суурин газарт унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр худаг гаргаж, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт олгохыг хязгаарлан ажиллаж байна. | | | |
| 67. | 12. | "Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр" №318, 2019-08-14 | Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд төмөр зам дагуу 2.5 га талбайд ойн зурвас байгуулж, 13.196 ширхэг мод тарих үйл ажиллагааг зохион байгууллаа. А1001 авто зам дагуу Эрдэнэт хотын угтах цэгт 3 га талбайд 500 ширхэг мод тарих, Эрдмин ХХК-ийн оролцоотой Хангал голын голдирол дагуу 10 га талбайд 100.000 ширхэг мод тарих зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийт 15.5 га талбайд 113.696 ширхэг мод тарьж, хөрс хамгаалах ойн зурвас байгууллаа. | -Төмөр зам дагуу ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах.<br>-А1001 авто зам дагуу Эрдэнэт хотын угтах цэгт мод тарих ажлыг зохион байнуулах.<br>-Хангал голын голдирол дагуу мод тарих зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. | Хөрс хамгаалах 15.5 га талбай ойн зурвас байгууллаа. | 100% Хэрэгжсэн |
| 68. | 13. | Дүрэм батлах тухай №33, 2019-01-23 | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм | Байгууллагын төрийн захиргааны 11 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан нийт 16 албан хаагч, ажилтан ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлан Төрийн албаны тухай хууль, | - Байгууллагын ёс зүйн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх<br>-Албан хаагчдад ёс зүй, харилцааа хандлагад нөлөөлөхө нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах ажил зэргийг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. | Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйн чиглэлэр мэдлэг нэмэгдсэн. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм, стандартыг сурталчилж, сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад ёс зүйн болон захиргааны зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй болно. Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хамтран зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" сэдэвт хойд бүсийн зөвлөгөөний Ёс зүйн дэд хороодыг чадавхижуулах салбар сургалтад хамрагдлаа. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2025 үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2 удаагийн сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа. | | | |
| 69. | 14. | Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №37, 2001-02-20 | Орон нутагт ажиллаж байгаа байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах болон бусад техник хэрэгсэл, уналгаар нормативын дагуу хангахын зэрэгцээ тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлэх ажлыг хамтран зохион байгуулсугай. | БОАЖС-ын 2022 оны А/456 дугаар “Жагсаалт, дүрэмт хувцасны иж бүрдэл, загвар батлах тухай” тушаалыг баримтлан ажлын даалгаврыг боловсруулж, Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүргүүлсний үндсэн дээр тендерт “Хотулун групп” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, Орхон аймгийн хэмжээнд байгаль орчны асуудалд хяналт тавин ажиллаж байгаа Байгаль орчны | Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцасыг сайжруулах. | Байгаль орчны хяналтын 15 байцаагч байгаль хамгаалагч иж бүрэн хувцас хэрэглэлээр хангагдсан. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нийт 15 албан хаагчдад иж бүрэн дүрэмт хувцас олгосон. | | | |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | | |
| **9.АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР** | | | | | | | |
| 70. | 1. | Хурлын байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2013-08-05 Дугаар 99 | АИТХ-ын байгууллагын бодлого шийдвэрийн биелэлтийг байгууллагын хэмжээнд дарга биечлэн хариуцаж, явцыг тухай бүр мэдээлдэг журамд шилжих. | Байгаль орчны салбарын чиглэлээр орон нутгийн хэмжээнд хэрэгжиж хугацаа дууссан аймгийн ИТХ-ын 3 тогтоол шийдвэрийг хасалт хийж, 2025 онд шинээр батлагдсан аймгийн ИТХ-ын 2 тогтоол шийдвэрүүдийг хяналтад авч, хэрэгжүүлэхээс гадна байгууллагын цахим хаяг, facebook хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллаж байна. | -Ой хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах<br>-Хуурайшилтын үед өдөр тутмын эргүүл шалагалтыг тогтмол зохион байгуулах<br>-Талбай тусгаарлалтын ажлыг СДОА-тай хамтран зохион байгуулах | Иргэдийг мэдээ, мэдээллээр хангана. | 100% Хэрэгжсэн |
| **9.АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР-6** | | | | | | | |
| 71. | 1. | "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2022-11-22 Дугаар 12/02 | 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн 2 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай. | Малчид тариаланчдын 2025 оны хаврын зөвлөгөөнөөр аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих төлөвлөгөөг танилцуулж, тариалангийн хөрс хамгаалах ойн зурвас байгуулах ажилд идэвхтэй оролцохыг газар тариалан эрхлэгчдэд уриалж, урилаж, 60 га талбайд ойн зурвас байгуулах тарьц, суулгацын нөөц бүрдүүллээ. | - | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар нэмэгдэнэ | 100% Хэрэгжсэн |
| 72. | 2. | "Хог хаягдлын менежментийг сайжруулах" | 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх | Аймгийн хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 120 тн хог | -Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д "Энэ хуулийн 8.1.14-т заасан | Хог хаягдлын менежментийг сайжруулахад төр, | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөр батлах тухай<br>2022-02-10<br>Дугаар 07/04 | үүсвэрийг улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай. | хаягдлыг цуглуулан төвлөрүүлж, Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан.<br>“Зэс эрдэнийн хувь” ХХК ажилчидын хоргүйжүүлэх бүтээгдэхүүний сав, баглаа боодол болох 96 кг хуванцар савыг “Витафит” ХХК-д, 8400ш/1.43тн/ артишокны шилийг “Газар шим” ХХК-д буцаан тушаасан.<br>Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 10 үйлдвэр, ААНБ-ын 573.291тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуйг ангилан ялгаж, тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэн устгуулсан байна.<br>Мөн ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг Элемент ХХК-д шилжүүлэн өгч устгууллаа.<br>Нийт 121.526тн энгийн, 573.6 тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуйг тус тус ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна<br>Төвлөрсөн суурин газрын хог хаягдлын нэгдсэн цэгт ландфилл байгуулах жишиг зураг төсвийг БОУАӨЯам газар хөдлөлтийн 6 балл, 7-8 балл, 9 баллийн ангиллаар гарган ирүүлсэн бөгөөд орон | жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй" гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд нарын хамтарсан А429/257 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах.<br>-Уулын гуу жалга, голын голдирол дагуу хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах. | хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэнэ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нутгийн оцлогт тохируулан сайжруулж, ТЭЗҮ хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөнд тусгууллаа. Орхон, Булган аймгийн хилийн зааг, орчны бүсийн нутаг дэвсгэрт нийт 32 цэгт хуримтлагдсан 650 $м^3$ хог хаягдлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажилладаг 27 ААНБ-уудын 713 ажилчдын хамруулан иж бүрэн цэвэрлэж, бохирдлыг буурууллаа. Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн сайдын үүрэг даалгаврын хүрээнд 76.4 км авто зам, төмөр замын дагуу хаягдсан 24м3 хог хаягдлыг цэвэрлэж, дарж устгууллаа. | | | |
| 73. | 3. | "Ногоон Эрдэнэт" хөтөлбөр батлах тухай 2022-02-10 Дугаар 07/02 | 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай. | Бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, 12 байршилд шинээр 429.45 мянган ширхэг мод шинээр тарьж, тарьсан модны хэмжээг 5.26 сая ширхэгт хүргээд байна. Баян-Овоот авто зам дагуу болон Эрдэнэт хаалга орчимд 2.3 га талбайд мод тарих арга хэмжээ зохион байгуулж, Ачит-Ихт ХХК Далайн хошууны шинэс ХХК-тай хамтран Хангал голын | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1 дэх зорилт | 429.5 мянган ширхэг мод тарьсан | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | голдирол дагуу 10 га талбайд 300.0 мянган ширхэг мод тарьж өссөн дүнгээр 14 га талбайд хүргэж, мод бут сөөг тарьц суулгац тарих хүсэлтэй иргэд олон нийтийг тарьц суулгацаар хангах зорилгоор мод, бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 34058 ширхэг борлуулагдаж, бүх нийтийн мод тарилт зохион байгуулагдсан 2 байршилд хар шорооны болон цэнэг усалгааны нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. | | | |
| 74. | 4. | "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөр батлах тухай<br>2024-02-29<br>Дугаар 18/04 | 1.Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булингаас үүсэлтэй цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тухайн бүсийн экологид учруулах нөлөөллийг бууруулах зорилгоор "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөрийг нэгдүгээр, "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.<br>2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын | Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг хүрээнд Хаягдлын аж ахуйн элстэй 1432 га талбайн хуурайшилттай 85%-ийг технологийн 4 төрлийн аргаар норголт хийж, тоосны дэгдэлтийг бууруулж байна.<br>Шинэ хаягдлын аж ахуй байгуулах ажлын суурь судалгааны ажил 100%, ТЭЗҮ, зураг төслийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>Тоосны тархалтын зонхилох 3 чиглэлийн 121 га талбайд 5 төрлийн 1.8 сая.ш мод, бутыг тарьж, арчлан ургуулж байна.<br>Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд Говил, Баянцагаан багийн Вокзалын хэсэг, Гаалийн газар, | тоос дарах технологийн ажлуудыг эрчимжүүлж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах олон талт ажлуудыг зохион байгуулах, Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд иргэдийг хамруулах | хуурайшилттай талбайн хэмжээ багасч, иргэд бодит мэдээллээр хангагдана. | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | захирал нарт тус тус даалгасугай. 3."Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хоёрдугаар үе шатны төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг 2027 оны IV улиралд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Түмэнжаргал), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Г.Ёндон)-д тус тус үүрэг болгосугай. | Эрдэнэт өртөө, Жаргалант сумаас нийт 500 иргэнийг хамруулж, зөвлөгөө өглөө.<br>Тоосны автомат 2 станцын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, дүнг www.Agaar.mn-д оруулж байна.<br>Сургалт мэдээллийн хүрээнд ЕБС-ийн 120 сурагчидад сургалт, 35 иргэнд хаягдлын аж ахуйн танилцуулга, 2 удаа тайлангийн өдөрлөг, 6 удаа тоосжилттой бүсийн иргэдэд нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгууллаа. | | | |
| 75. | 5. | Дүгнэлт өгөх, төлөвлөгөө батлах тухай<br>2024-11-13<br>Дугаар 03/04 | 1.Аймгийн хэмжээнд 2024 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлыг "Бүрэн хэрэгжсэн" гэж дүгнэсүгэй.<br>2.Аймгийн хэмжээнд 2025 ондой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.<br>3.Аймгийн хэмжээнд 2025 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц, 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны IV улиралд багтаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-т даалгасугай. | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн захиргааны байгууллагуудтай хамтарсан болон байгаль хамгаалагчийн өдөр дутмын эргүүл, хяналт шалгалтыг 63 хоногийн хугацаанд зохион байгуулж 900 гаруй иргэн 33 ААНБ-д, 26 малчин өрх, 14 ойн нөхөрлөлд 832 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шинэчилсэн гарын авлага түгээж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн Газраас хэрэгжүүлж байгаа "Ойн түймэртэй тэмцэх, чадавхыг сайжруулах" төслийн хүрээнд 16 ойн нөхөрлөлд 7 | | | 100% Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төрлийн 55 ширхэг ой, хээрийн түймэр унтраах багаж, анхны тусламжын хэрэгслийг олгож, дэмжлэг үзүүлж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-д танилцуулж, аймгийн хэмжээнд 2026 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2025 оны 03/51 дүгээр тогтоолоор батлуууллаа. | | | |
| 76. | 6. | Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ батлах тухай<br>2024-11-13<br>Дугаар 03/03 | 1.Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөг харгалзан 2025 онд Жаргалант сумын хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг 900 шоо метрээр баталж, дараах хэмжээгээр тогтоосугай.<br>1.1.Ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 100 шоометр;<br>1.2.Түлээний шинэс мод 800 шоометр.<br>2.Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл тоо, хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй. | Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/11 тоот тогтоолын дагуу Жаргалант сумын ойн сангийн 180 га талбайгаас 900 шоометр мод бэлтгэх эрхийн бичгийг 265 иргэнд олгож, 1.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ. | -Талбайн тусгаарлалтын ажлыг Жаргалант сумын Шувуут, Цагаан хуст, Согоот, Урт зэрэг байршлуудад зохион байгуулах | Иргэдийн тодорхой хувийг түлшний модоор хангах боломжтой болсон. | 100% Хэрэгжсэн |

**Хэсгийн дундаж хувь: 100%**

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Г.ЗОЛБОО